



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 09 дугаар
сарын 07 өдөр

Дугаар А/188

Улаанбаатар
хот

Төрийн албан хаагчдын амралт
сувилтын газар байгуулах тухай

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн
4-ийн 5 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зайсан дахь Ясны сүрьеэгийн эмнэлэг байсан хуучин барил-
гыг Нийслэлийн Төрийн албан хаагчдын амралт сувиллын газар бол-
гохоор өөрчлөн засварлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
\н.Болдсайхан\ -т даалгасугай.

✓ 2. Ясны сүрьеэгийн эмнэлгийн байрыг засварлахад шаардлага-
тай хөрөнгийн өх үүсвэрийг 1996-1997 оны хөрөнгө оруулалт, их
засварын төлөвлөгөөнд тусган тогтоохыг Нийслэлийн Засаг даргын
Тамгын газрын Нийгэм, эдийн засгийн бодлогын хэлтэс \н.Бат\ -т
даалгасугай.

✓ 3. Амралтын барилгын дулаан, усан хангамжийн шийдэл, амралт,
түүний орчны тохижилтын зураг төсвийг 1995 оны IY улиралд багтаан
боловсруулж батлуулахыг Барилга, хот байгуулалтын алба
\н.Жадамбаа\ -нд үүрэг болгосугай.

4. Төрийн албан хаагчдын амралтын барилгын хөрөнгийн өх
үүсвэр, зураг төсвийг хугацаанд нь шийдвэрлүүлэн, засварын ажлын
явцад хяналт тавьж 1997 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтанд
оруулах арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
\н.Болдсайхан\ -т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БҮГДЭД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БААСАНЖАВ